



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/124

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 05 дугаар “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил”-д 158,988,418 (нэг зуун тавин найман сая есөн зуун наян найман мянга дөрвөн зуун арван найм) төгрөгийг зарцуулсугай.

2.Сумын “Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил”-д 158,988,418 (нэг зуун тавин найман сая есөн зуун наян найман мянга дөрвөн зуун арван найм) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжид хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА